



МОНГОЛ УЛСЫН
АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/103

Улаанбаатар хот

Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг
тооцох журам батлах тухай

АШУУИС-ийн дүрмийн 4.8, 4.8.6 дахь заалтууд, АШУУИС-ийн Захиргааны зөвлөлийн 2021 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. АШУУИС-ийн багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журмыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Журмыг 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төгсөлтийн өмнөх сургалтын бодлого зохицуулалтын газар (Я.Энхтөр), Төгсөлтийн сургалтын бодлого зохицуулалтын газар (А.Шийрэвнямба), Мэргэжил дээшлүүлэх институт (Т.Баясгалан), Багшийн хөгжил, цахим сургалтын газар (С.Хандмаа), Бүрэлдэхүүн болон салбар сургуулиудын захирал нарт үүрэг болгосугай.

3. Уг тушаал гарсантай холбогдуулан АШУУИС-ийн Захирлын 2016 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн А/118 тоот тушаал “Багшийн үйл ажиллагааг зохицуулах журам”, 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/147 тоот тушаал “Зөвлөх болон гэрээт багш ажиллуулах журам”, 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/415 тоот тушаал “Багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам”, 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/224 тоот тушаалыг тус тус хүчингүй болгосугай.


4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол хариуцсан дэд захирал (Г.Батбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Н.ХҮРЭЛБААТАР

3350210103

АШУҮИС-ийн Захирлын үүрэг гүйцэтгэгчийн
2021 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн
А/403 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



АШУҮИС-ийн багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, АШУҮИС-ийн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, “Багшийн алтан дүрэм”-ийн хүрээнд АШУҮИС-ийн багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг энэ журмаар зохицуулна.
- 1.2 АШУҮИС-ийн багшлах бүрэлдэхүүн нь үндсэн, гэрээт, зочин багшаас бүрдэх ба жил бүр АШУҮИС-ийн захирлын тушаалаар шинэчлэн батална.

Хоёр. Багшийн сонгон шалгаруулалт

- 2.1. Багшийн хөгжил, цахим сургалтын газар (БХЦСГ), Захиргаа, хүний нөөцийн газар (ЗХНГ)-тай хамтран багш шинээр авах ажлыг зохион байгуулна.
- 2.2. Багшийн сонгон шалгаруулалтыг АШУҮИС-ийн захирлын тушаалаар томилогдсон Багшийн хөгжлийн зөвлөл (дэд захирал, бүрэлдэхүүн сургуулийн захирал, холбогдох газрын дарга, профессор багш нараас бүрдэнэ) хийнэ.
- 2.3. Багшийн сонгон шалгаруулалтыг жил бүрийн 8-р сарын сүүлийн хагаст зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд 2-р улирлын эхэнд сонгон шалгаруулалт зарлаж болно.
- 2.4. Тэнхимийн саналыг үндэслэн Төгсөлтийн өмнөх сургалтын бодлого зохицуулах газар (ТӨСБЗГ) тэнхимийн ачаалал, багшийн хэрэгцээ, орон тоог тодорхойлж, БХЦСГ-аас ажлын байрны зарыг 14 хоногоос багагүй хугацааны өмнө мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлана.
- 2.5. Сонгон шалгаруулалтад оролцогчдод тавих нийтлэг шаардлага:
 - 2.5.1. Магистр, түүнээс дээш зэрэг, цолтой байх;
 - 2.5.2. Мэргэшүүлэх сургалтыг дүүргэсэн байх буюу мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан байх;
 - 2.5.3. Англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх;
- 2.6. Багшийн сонгон шалгаруулалтыг сорилын шалгалт, ярилцлага гэсэн үе шаттай зохион байгуулна.
- 2.7. Сорилын шалгалт мэргэжил (50%), англи хэл (30%), ёсзүй (20%) гэсэн бүтэцтэй байна. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн англи хэлний шалгалтын дүнг шууд тооцно.
- 2.8. Сорилын шалгалтад 60-аас дээш үнэлгээ авсан тохиолдолд холбогдох тэнхимийн эрхлэгчийг оролцуулан Багшийн хөгжлийн зөвлөлийн ярилцлагад орно.
- 2.9. Сонгон шалгаруулалтад тэнцсэн багш АШУҮИС-ийн Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шаардлагатай материал бүрдүүлнэ.

- 2.10. Ярилцлагын дүнг үндэслэн хөдөлмөрийн гэрээ байгуулах саналыг ЗХНГ-т танилцуулж, АШУҮИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.
- 2.11. Мэргэжлийн мэдлэг, ур чадвар өндөртэй шилдэг судлаач, эмч, мэргэжилтэнтэй хөдөлмөрийн гэрээ шууд байгуулж болно.

Гурав. Багшийн ажлын үнэлгээ ба багшлах эрхийг баталгаажуулах

- 3.1. БХЦСГ багшийг хөгжүүлэх, идэвхжүүлэх, албан тушаалын зэрэглэл өөрчлөх зорилгоор багшийн ажлын үнэлгээг жилд хоёр удаа зохион байгуулна.
- 3.2. Багшийн ажлын үнэлгээнд хамрагдах багш нарын нэрсийг Захирлын тушаалаар батална.
- 3.3. Багшийн ажлыг өөрийн үнэлгээний тайлан, нотлох баримтад тулгуурлан Боловсрол хариуцсан дэд захирлын баталсан үлгэрчилсэн шалгуур үзүүлэлтээр үнэлнэ. Үнэлгээ нь зөвлөлийн үнэлгээ, оюутны үнэлгээ, тэнхимийн эрхлэгчийн үнэлгээнээс бүрдэнэ.
- 3.4. Шинээр орсон дадлагажигч багшийг эхний болон 3 дахь жилд үнэлэх ба үнэлгээ нь хөдөлмөрийн гэрээг сунгах эсвэл цуцлах үндэслэл болно.
- 3.5. Албан тушаалын зэрэглэлээр нь “багш”-ийн ажлыг 3 жил тутам, “ахлах багш”, “дэд профессор”-ийн ажлыг 4 жил тутам, “профессор” багшийн ажлыг 5 жил тутамд тус тус үнэлнэ.
- 3.6. Тэнхимийн эрхлэгчийн ажлыг Захирлын тушаалаар баталсан удирдамжийн хүрээнд холбогдох сургалт хариуцсан газар, хамт олны саналыг үндэслэн 2 жил тутамд үнэлнэ.
- 3.7. БХЦСГ-аас багшийн ажлын үнэлгээний нэгдсэн дүнг ажлын 10 хоногт багтаан гаргаж Багшийн хөгжлийн зөвлөлөөр хэлэлцэн баталгаажуулна.
- 3.8. Багшийн ажлын үнэлгээ нь зөвлөлийн, тэнхимийн эрхлэгчийн, оюутны үнэлгээнээс бүрдэх ба Хүснэгт.1-д заасан жишиг оноогоор тооцно.

| Багшийн албан тушаалын зэрэглэл | Өөрийн үнэлгээний тайланд үндэслэсэн зөвлөлийн үнэлгээ | | | Тэнхимийн эрхлэгчийн үнэлгээ | Хүснэгт 1. |
|---------------------------------|--|-----------------|--------------------------|------------------------------|----------------|
| | Сургалт | Эрдэм шинжилгээ | Мэргэжлийн үйл ажиллагаа | | Оюутны үнэлгээ |
| | | | | | |
| Профессор | 15 | 35 | 25 | 20 | 5 |
| Дэд профессор | 20 | 30 | 20 | 20 | 10 |
| Ахлах багш | 25 | 25 | 20 | 20 | 10 |
| Багш | 30 | 20 | 20 | 20 | 10 |
| Дадлагажигч багш | 35 | 20 | 15 | 20 | 10 |

- 3.9. Багшийн ажлын үнэлгээ 80-аас дээш бол “сайн”, 70-79 оноо бол “хангалттай”, 69-өөс бага бол “хангалтгүй” гэж дүгнэх ба “хангалтгүй” үнэлүүлсэн бол ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл болно.
- 3.10. БХЦСГ нь багшлах эрхийн гэрчилгээ олгох, сунгах ажлыг зохион байгуулах ба Захирлын тушаалаар баталгаажуулна.

3.11. Тэнхимийн саналыг үндэслэн нарийн мэргэшлийн эмч, мэргэжилтэн, судлаачийг гэрээт багшаар ажиллуулж болно. Гэрээт багш нь АШУҮИС-ийн багшид тавигдах нийтлэг шаардлагыг хангасан байх ба захирлын тушаалаар баталгаажуулж, бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал гэрээ байгуулна.


Дөрөв. Багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх

- 4.1. АШУҮИС-ийн тэнхимүүдийг сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагааны чиглэлээр нь ерөнхий эрдмийн, анагаахын суурь боловсролын, эмнэлзүйн тэнхим гэж ангилна (хавсралт 5).
- 4.2. Багшийн гүйцэтгэсэн сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн ажлыг оноогоор тооцох ба нийлбэр нь албан тушаалын зэрэглэл харгалзахгүйгээр 1600 байна (долоо хоногийн ажлын 40 цагийг хичээлийн жилийн үргэлжлэх 40 долоо хоногоор үржүүлсэнтэй тэнцэнэ)
- 4.3. Тэнхимийн багшийн гүйцэтгэлийг тооцохдоо Хүснэгт 2-т заасан жишгийг баримтална.

| | | | Хүснэгт 2. | | | | |
|------------------------------------|---------------|--------|------------|---------------|------------|------|------------------|
| | | | Профессор | Дэд профессор | Ахлах багш | Багш | Дадлагажигч багш |
| Ерөнхий эрдмийн тэнхим | Сургалт | Хичээл | 560 | 600 | 640 | 680 | 720 |
| | | Явц | 280 | 300 | 320 | 340 | 360 |
| | ЭШ | | 210< | | | | |
| | МҮА | | 210< | | | | |
| Анагаахын суурь боловсролын тэнхим | Сургалт | Хичээл | 520 | 560 | 600 | 640 | 680 |
| | | Явц | 260 | 280 | 300 | 320 | 340 |
| | ЭШ | | 310< | | | | |
| | МҮА | | 170< | | | | |
| Эмнэлзүйн Тэнхим | Сургалт | Хичээл | 480 | 520 | 560 | 600 | 640 |
| | | Явц | 240 | 260 | 280 | 300 | 320 |
| | ЭШ | | 270< | | | | |
| | Эмнэлзүй, МҮА | | 270< | | | | |

Тайлбар: Тухайн жилд Сургалт, Эрдэм шинжилгээ (ЭШ), Эмнэлзүй, мэргэжлийн үйл ажиллагаа (МҮА)-ны ачааллын нийлбэр 1600 байна. ЭШ, МҮА-аар заавал гүйцэтгэх оноог тэнхимийн үйл ажиллагааны онцлогт тулгуурлан шилжүүлж болно.

- 4.4. Тэнхимийн эрхлэгч нь багшийн эрдмийн зэрэг цол, мэргэжлийн ур чадварыг харгалзан сургалтаар гүйцэтгэх ачааллыг 30 хүртэлх хувиар хөнгөлж болно. Хөнгөлсөн ачааллыг эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаагаар заавал биелүүлнэ.
- 4.5. Гэрээт багшийн сургалтын гүйцэтгэлийг илүү онооны үнэлгээгээр, зочин багшийн сургалтын гүйцэтгэлийг багшийн албан тушаалын зэрэглэлд үндэслэн тооцно.
- 4.6. Хөнгөлөлт урамшуулал:
- 4.6.1. Тэнхимийн эрхлэгчийн ур чадварын нэмэгдлийг Их сургуулийн Захирлын тушаалаар баталгаажуулж олгоно.
- 4.6.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн тухай хууль, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дүгнэлтийг үндэслэн хөдөлмөрийн тусгай



нөхцөлд ажиллаж буй багшийн цагийн ачааллын хөнгөлөлтийг хөдөлмөрийн гэрээнд тусгаж хэрэгжүүлнэ.


- 4.6.3. Гадаад, дотоодын санхүүжилттэй төслөөс их сургуульд оруулсан мөнгөн дүнгийн хэмжээнээс хамаарч багшийн сургалтын ачааллаас тодорхой хувиар хөнгөлж болно.
- 4.6.4. Тухайн эмнэлэг, сургууль нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон лабораторийн гүйцэтгэсэн орлогын 5-10 хувийг багшид урамшуулал болгон олгоно.
- 4.6.5. Хувийн эмнэлэгт давхар ажилладаг багш сургалтын ачааллаа 20 хүртэлх хувиар хөнгөлүүлж болох ба ажлын өдөр, хөдөлмөрийн хөлсийг дээрх хөнгөлөлттэй дүйцүүлэн хөдөлмөрийн гэрээнд тусгасан байна.
- 4.6.6. Блокийн зохицуулагч (координатор) багшийн гүйцэтгэх сургалтын ачааллаас 40 оноо хөнгөлж болно.
- 4.6.7. Тэнхимийн багшийн сургалтын ачааллын хөнгөлөлтийг давхардуулан тооцохгүй.
- 4.7. Сургалтын ачааллыг тооцох
- 4.7.1. Ахлах багш, дэд профессор, профессор багш сургалтын ачааллын 30 хүртэлх хувийг төгсөлтийн, төгсөлтийн дараах сургалтаар гүйцэтгэж болно.
- 4.7.2. Багш сургалтын ачааллаа гүйцэтгэсэн тохиолдолд явцын оноог (лекц, семинар, дадлагын хичээлд бэлтгэх, сорил, тохиолдол боловсруулах, бие даалтыг үнэлэх гэх мэт) шууд тооцож, тэнхимийн эрхлэгч баталгаажуулна.
- 4.7.3. Ажлын бус цагаар, амралтын өдрүүдэд гүйцэтгэсэн ажлын хөлсийг хөдөлмөрийн хуулийн дагуу тооцож олгож болно.
- 4.7.4. Салбар, бүрэлдэхүүн сургуулийн захирлууд 100-аас цөөнгүй онооны сургалтын ачаалал гүйцэтгэнэ.
- 4.7.5. Багш сургалтаар 60 хүртэл хувь илүү оноо гүйцэтгэж болно. Гэрээт багш 400 оноо хүртэл сургалтын ачаалал гүйцэтгэнэ.
- 4.8. Төгсөлтийн өмнөх сургалтаар багшийн гүйцэтгэсэн ажлыг үнэлэх
- 4.8.1. Төгсөлтийн өмнөх сургалтын ачааллыг оноонд шилжүүлэхдээ Хүснэгт.3-т заасан жишгийг баримтална.

Хүснэгт 3.


| Хэлбэр | Хугацаа | Оноо | Суралцагчдын тоо |
|---------------------|---------|------|-------------------|
| Лекцийн хичээл | 1 цагт | 2 | 1 поток |
| Дадлагын хичээл | 1 цагт | 1 | 1 хэсэг |
| Семинарын хичээл | 1 цагт | 1.5 | 1 бүлэг (2 хэсэг) |
| Том бүлгийн хичээл* | 1 цагт | 1.5 | 2-оос дээш хэсэг |

* Гадаад хэл, биеийн тамир, мэдээллийн технологи, мэдээллийн систем зэрэг дадлагын хичээл


- 4.8.2. Тэнхимийн докторант 80, магистрант 40 онооны сургалтын ачааллыг багшийн удирдлагад гүйцэтгэх ба гүйцэтгэлийн 50 хүртэлх хувийг удирдсан багшид тооцно.



- 4.8.3. Зуны дадлага удирдсан багшийн гүйцэтгэлийг 7 хоногт 1 оюутанд 2 оноогоор бодож илүү онооны үнэлгээгээр тооцно.
- 4.8.4. АШУУИС-ийн Захирлын тушаалаар батлагдсан элсэлт, төгсөлтийн шалгалтын комиссын гишүүдийн ажилласан 1 цагийг 1 оноогоор бодож илүү онооны үнэлгээгээр тооцно.
- 4.8.5. Оюутны төгсөлтийн диплом удирдсан ажил тус бүрд 40 оноо, шүүмж бичсэн ажил бүрд 10 оноогоор илүү онооны үнэлгээгээр тооцно.
- 4.9. Төгсөлтийн сургалтаар багшийн гүйцэтгэсэн ажлыг үнэлэх (хавсралт 3)
- 4.9.1. Төгсөлтийн сургалтын гүйцэтгэлийг тэнхимийн эрхлэгч тооцож, Төгсөлтийн сургалтын бодлого зохицуулалтын газар хянаж баталгаажуулна.
- 4.9.2. Эрдмийн сургуулийн багшийн сургалтын ачааллыг төгсөлтийн сургалтаар тооцно.
- 4.9.3. Эрдмийн сургуулийн багшийн сургалтын ачааллын 30 хүртэл хувийг төгсөлтийн өмнөх, төгсөлтийн дараах сургалтаар тооцож болно.
- 4.9.4. Төгсөлтийн танхимын сургалтаар анги, хэсэг үүссэн тохиолдолд 3-р хүснэгтийн жишгээр бусад тохиолдолд 3-р хавсралтын дагуу гүйцэтгэлийн тооцно.
- 4.9.5. Магистрын цахим сургалтаар гүйцэтгэсэн оноог 4-р хавсралтын дагуу тооцно. 30 суралцагчаас бүрдсэн хэсэг үүссэн тохиолдолд дадлагын хичээлийг 3-р хүснэгтийн жишгээр, бусад тохиолдолд 3 дугаар хавсралтын дагуу тооцно.
- 4.9.6. Хамгаалсан магистр, докторын ажлын нэг сэдэвт бүтээлд ноогдох онооны 75%-ийг удирдагч багшид, 25%-ийг зөвлөхөд, магистрын цахим сургалтын төслийн удирдагчид 25 хувь байхаар тооцож илүү онооны үнэлгээгээр олгоно.
- 4.9.7. Докторын ажлын шүүмжлэгчид 30 оноо, магистрын ажлын шүүмжлэгчид 20, магистрын цахим сургалтын судалгааны төслийн шүүмжлэгчид 10 оноогоор тооцож илүү онооны үнэлгээгээр олгоно.
- 4.10. Төгсөлтийн дараах сургалтаар багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх
- 4.10.1. Төгсөлтийн дараах сургалтын гүйцэтгэлийг Мэргэжил дээшлүүлэх институт тооцож баталгаажуулна.
- 4.10.2. Эмнэлзүйн тойролт хариуцсан багш долоо хоногт 5 хүртэлх суралцагчийг дадлагажуулах ба гүйцэтгэлийг тэнхимийн эрхлэгч, координатор багш хянана.
- 4.10.3. Сонгон суралцах нэг багц цагийн хичээлийг (25 ба түүнээс дээш суралцагчтай анги үүссэн тохиолдолд) 20 оноо,
- 4.10.4. Үндсэн мэргэшлийн сургалтаар 7 хоногт 5 хүртэлх суралцагч дадлагажуулсан эсвэл эмнэлзүйн тойролт хариуцсан бол 1.2 оноо,
- 4.10.5. Төрөлжсөн болон мэргэжил дээшлүүлэх сургалтаар 7 хоногт 1 суралцагч дадлагажуулсан бол 1.5 оноо,
- 4.10.6. Зохицуулагч (координатор) багшид суралцагч бүрд 3 оноогоор тооцож тус тус илүү онооны үнэлгээгээр олгоно.
- 4.11. Эрдэм шинжилгээний ажлыг үнэлэх (хавсралт 1)



- 4.11.1. Эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийг Шинжлэх ухаан технологийн газар (ШУТГ) баталгаажуулах ба гүйцэтгэлийг 2 жилийн хугацаанд хуримтлуулан тооцож болно.
 - 4.11.2. Эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийн дутуу оноог сургалтын оноогоор нөхөн тооцуулж болно.
 - 4.11.3. Эрдэм шинжилгээний төслийн урамшуулал, хөнгөлөлт тооцох бол ШУТГ, Санхүү эдийн засгийн газартай гэрээ байгуулсан байна.
 - 4.11.4. Захирлын тушаалаар баталгаажсан бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажиллахад хичээлийн жилд сургалтын ачааллаас 40 оноог хөнгөлж тооцно.
- 4.12. Мэргэжлийн үйл ажиллагааг үнэлэх (хавсралт 2)
- 4.12.1 БХЦСГ-тай хамтран зохион байгуулсан сургалт болон бусад ажлыг багшийн мэргэжлийн үйл ажиллагаанд тооцуулж болно.
 - 4.12.2 Эмнэлзүйн тэнхимийн багш АШУҮИС-ийн эмнэлэгт долоо хоногт 8-аас доошгүй цаг ажиллах ба гүйцэтгэлийг эмнэлгийн бүртгэл, мэдээлэлд үндэслэн Их Сургуулийн Эмнэлгийн хөгжлийн газар баталгаажуулна.
 - 4.12.3 Сургалтын түшиц, гэрээт эмнэлэгт ажиллаж буй багшийн эмнэлзүйн ачааллыг байгууллагын тодорхойлолт, гэрээг үндэслэн бүрэлдэхүүн сургуулийн захирал баталгаажуулах ба эмнэлзүйн ачааллын дутуу оноог сургалтын оноогоор нөхөн тооцуулж болно.
- 4.13. Багшийн ажлын ачааллыг тогтоох, тооцох, гүйцэтгэлийг үнэлэх
- 4.13.1. Тэнхимийн эрхлэгч нь багш нарын эрдмийн зэрэг, цол, мэргэжлийн ур чадварыг харгалзан сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагааг нээлттэй, шударга хуваарилах ба бүрэлдэхүүн сургуулийн захирал гүйцэтгэл, үр дагаврыг шууд хариуцна.
 - 4.13.2. Сургалтын ачааллаас тухайн багшийн хөнгөлүүлсэн оноог тэнхимийн илүү цагт тооцохгүй.
 - 4.13.3. Тэнхимийн эрхлэгч нь хагас жил тутамд багш нарын ажлын гүйцэтгэлийг тэнхимийн хурлаар хэлэлцэж дүгнэнэ.
 - 4.13.4. Тэнхимийн эрхлэгч нь дараагийн хичээлийн жилийн сургалтын ачааллыг тооцон багш нарын гарын үсгээр баталгаажуулан сургалт хариуцсан газарт 6-р сард багтаан ирүүлнэ.
 - 4.13.5. Сургалтын төлөвлөгөөг үндэслэн тэнхимүүдийн гүйцэтгэх ачааллыг Боловсрол хариуцсан дэд захирал баталгаажуулна.
 - 4.13.6. Тэнхимийн эрхлэгч нь сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаагаар тэнхимийн гүйцэтгэсэн нийт оноо болон багш бүрийн гүйцэтгэлийн нэгтгэлийг бүрэлдэхүүн сургуулийн захирлаар баталгаажуулж, нотлох баримтын хамт хариуцсан газар, нэгжид ирүүлнэ.







Эрдэм шинжилгээний гүйцэтгэлийн үнэлгээ

| Үзүүлэлт | Тайлбар | Хэнд олгох | Оноо |
|--|---|---|--------|
| Шинжлэх ухааны доктор хамгаалах | Тухайн хамгаалсан жилд | Багш, ажилтанд | 450 |
| Докторын зэрэг хамгаалах | Тухайн хамгаалсан жилд | Багш, ажилтанд | 360 |
| Scopus, Web of Science, PubMed мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлийн редакцын зөвлөлд ажиллах | Тухайн жилийн турш ажилласан нэг сэтгүүл | Редакцын гишүүн | 240 |
| Scopus, Web of Science, PubMed мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлийн өгүүлэлд шүүмж бичих | Тухайн жилд ажилласан нэг өгүүлэл (хэвлэгдсэн байх) | Шүүмж бичигч | 48 |
| АШУҮИС-ийн нэрээр Scopus, Web of Science, PubMed мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх | Тухайн жилд | Хариуцлагатай зохиогч | 480 |
| | Тухайн жилд | Нэгдүгээр зохиогч | 360 |
| | Тухайн жилд | Хамтран зохиогч | 130 |
| АШУҮИС-ийн нэрээр Scopus, Web of Science, PubMed мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд иш татагдсан тоо | Тухайн жилд иш татагдсан удаа бүрд | Зохиогч тус бүрд | 12 |
| Олон улсын болон дотоодын санхүүжилттэй төсөл хэрэгжүүлэх (гэрээг үндэслэнэ). АШУҮИС-ийн ШУТДС-ийн төсөл хамаарахгүй | 100 сая хүртэл | Удирдагч | 200 |
| | | Зохицуулагч, зөвлөх | 90 |
| | 100-300 сая | Гишүүн | 50 |
| | | Удирдагч | 260 |
| | | Зохицуулагч, зөвлөх | 80 |
| | | Гишүүн | 65 |
| | 300 саяас дээш | Удирдагч | 320 |
| | | Зохицуулагч, зөвлөх | 100 |
| | | Гишүүн | 80 |
| | Оюуны өмч | Олон улсын хэмжээнд (Мадридын хэлэлцээрт хамрагдаагүй улсад бүртгэгдсэн тохиолдол бүрд) | Патент |
| Бүтээгдэхүүний загвар | | | 240 |
| Дотоодын (тухайн жилд тооцно) | | Шинэ бүтээлийн патент | 240 |
| | | Ашигтай загвар | 180 |
| | | Бүтээгдэхүүний загвар | 120 |
| | Монгол улсын стандарт | 200 | |
| | Зохиогчийн эрх | 100 | |

| | | | |
|---|--|-----------------------|----|
| Дотоодын сэтгүүлийн редакцын зөвлөлд ажиллах | Тухайн жилийн турш ажилласан нэг сэтгүүл | Редакцын гишүүн | 60 |
| Хөндлөнгийн шинжээч бүхий, ISSN, eISSN кодтой дотоодын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх | Тухайн жилд хэвлүүлсэн нэг өгүүлэл | Хариуцлагатай зохиогч | 72 |
| | | Нэгдүгээр зохиогч | 48 |
| | | Хамтран зохиогч | 24 |
| Олон улсын хуралд илтгэл хэлэлцүүлэх (илтгэлийн хураангуйд хэвлэгдсэн байх) | Тухайн жилд хэлэлцүүлсэн илтгэл бүрд (Нэгдүгээр, хариуцлагатай зохиогч нарт) | Уригдсан илтгэл | 72 |
| | | Аман илтгэл | 48 |
| | | Ханын илтгэл | 24 |
| Үндэсний хэмжээний хуралд илтгэл хэлэлцүүлэх (илтгэлийн хураангуйд хэвлэгдсэн байх) | Тухайн жилд хэлэлцүүлсэн нэг илтгэл бүрд | Уригдсан илтгэл | 24 |
| | | Аман илтгэл | 12 |
| | | Ханын илтгэл | 6 |





Мэргэжлийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн үнэлгээ

| Мэргэжлийн үйл ажиллагаа | Хэмжих нэгж | Оноо | Тайлбар |
|--|---|------------|--------------------------------------|
| АШУҮИС-ийн эмнэлэг, сувилалд ажиллах | Долоо хоногт 8-аас доошгүй цаг | 320 | Тухайн жилд |
| Хүрээлэн, төв, лаборатори, эмийн сан, эмийн үйлдвэр, сувилал удирдах, хариуцаж ажиллах | Тухайн жилд | 200 | Нэмэлт урамшуулал аваагүй тохиолдолд |
| Эмнэлзүй, технологийн заавар, үндэсний хэмжээний хөтөлбөр, эмийн шинжилгээний лабораторийн болон үйлдвэрийн холбогдох баримт, бичиг боловсруулах | 1 баримт бичиг | 100 | Батлагдсан жилд |
| Гарааны компани байгуулж, ажиллах | 1 бүтээмж | 100 хүртэл | Бүтээмжээс хамаарна |
| Олон улсын мэргэжлийн нийгэмлэг холбооны тэргүүн, дэд тэргүүн, удирдах зөвлөлд ажиллах | Гэрчилгээ, үнэмлэх | 90 | Тухайн жилд |
| Олон улсын мэргэжлийн нийгэмлэг холбооны гишүүн | Гэрчилгээ, үнэмлэх | 70 | Тухайн жилд |
| Яамны салбар зөвлөлийн дарга, нарийн бичгээр ажиллах | Тушаал | 50 | Тухайн жилд |
| Яамны салбар зөвлөлийн гишүүнээр ажиллах | Тушаал | 30 | Тухайн жилд |
| АШУҮИС-ийн хэмжээнд ажлын хэсэгт ажиллах | Ажлын хэсэг бүрт | 30 | Тушаалаар |
| Бүрэлдэхүүн, салбар сургууль, эмнэлгийн захирлын тушаалаар ажлын хэсэгт ажиллах | Тушаал | 10 | Тухайн жилд |
| Дотоодын мэргэжлийн нийгэмлэг, холбооны удирдах зөвлөл, тэргүүн, нарийн бичгээр ажиллах | Үнэмлэх, тушаал, тодорхойлолт | 30 | Тухайн жилд |
| Дотоодын мэргэжлийн нийгэмлэг, холбооны гишүүн | Үнэмлэх, тушаал, тодорхойлолт | 10 | Тухайн жилд |
| Мэргэжлийн чиглэлээр тэмцээнд оролцох, зохион байгуулах | 1 тэмцээн | 30 | Тухайн жилд |
| Мэргэжлийн чиглэлээр сургалт зохион байгуулах | 1 сургалт | 50 | Тухайн жилд |
| Олимпиад зохион байгуулах, комисст ажиллах | Олон улсын хэмжээнд | 80 | Тухайн жилд |
| | Улсын хэмжээнд | 60 | |
| | Сургуулийн хэмжээнд | 40 | |
| Олимпиад зохион байгуулах, комисст ажиллах | 1 олимпиад, уралдаан | 40 | Тухайн жилд |
| | Бүрэлдэхүүн сургууль, салбарын хэмжээнд | 20 | |
| Суралцагчдад зориулсан дугуйлан, секц ажиллуулах | 1 цагт | 5 | Тухайн жилд |

| | | | | |
|--|-----------|-------------------------------------|---------------|---|
| Мэргэжлийн зэрэг ахиулах | Зөвлөх | Үнэмлэх | 200 | Тухайн жилд |
| | Тэргүүлэх | | 150 | |
| | Ахлах | | 100 | |
| Мэргэжлийн зэрэг | Зөвлөх | Үнэмлэх | 50 | Тухайн жилд |
| | Тэргүүлэх | | 35 | |
| | Ахлах | | 20 | |
| Олон нийтэд зориулсан сургалт, зөвлөгөө, мэдээ, мэдээлэл ярилцлага | | Ажил тус бүр | 5 | Тухайн жилд |
| Анги даасан зөвлөх багш | | 1 анги | 40 | Тухайн жилд |
| Оюутны клуб удирдах | | 1 клуб | 20 | Тухайн жилд |
| Хамтын ажиллагаатай байгууллагад зөвлөхөөр ажиллах | | Гэрээ, тушаал | 50 | Тухайн жилд |
| Сургуульд оруулсан хөрөнгө оруулалт, мөнгөн орлого | | 1 сая төгрөгийн цэвэр орлого тутамд | 40 | Багш нэмэлт урамшуулал аваагүй тохиолдолд |
| Багшийн хөгжил, мэргэжлийн чиглэлээр сургалтад хамрагдах | | Суусан цагаар | 1 цагт/2 оноо | Тухайн жилд |
| Нээлттэй хичээл зохион байгуулах | | | 1 цагт/2 оноо | Тухайн жилд |
| Профессор, дэд профессор багшийн хичээлд сууж дагалдан суралцах | | | 1 цагт/2 оноо | Тухайн жилд |
| Сурах бичиг бичих | | Хэвлэлийн хуудас бүрд | 5 | Зохиогч бүрд |
| Сурах бичиг орчуулах | | Хэвлэлийн хуудас бүрд | 5 | Зохиогч бүрд |
| Гарын авлага хэвлүүлэх | | Хэвлэлийн хуудас бүрд | 2 | Зохиогч бүрд |
| Сурах бичиг редакторлах | | Хэвлэлийн хуудас бүрд | 2 | Редактор бүрд |
| Тарималжуулалтын талбайд ажиллах | | Ажилласан цагаар | 1цаг/1 оноо | Тухайн жилд |
| АШУҮИС-ийн лаборатори, эмийн сан, эмийн үйлдвэрт ажиллах | | Ажилласан цагаар | 1цаг/1 оноо | Нэмэлт урамшуулал аваагүй тохиолдолд |
| Албан ёсоор айлчилж буй гадаадын зочдод орчуулга хийх | | Ажилласан цагаар | 1цаг/1 оноо | Тухайн жилд |



**Төгсөлтийн сургалтаар багшийн гүйцэтгэлийн үнэлгээ
(Анги, хэсэг бүрдээгүй тохиолдолд)**

| Оюутны тоо | 1 багц цагийн хичээлийн оноо | | 2 багц цагийн хичээлийн оноо | | 3 багц цагийн хичээлийн оноо | |
|-----------------------|------------------------------|------------------------|------------------------------|------------------------|------------------------------|------------------------|
| | Илүү оноогоор тооцох | Үндсэн ачаалалд тооцох | Илүү оноогоор тооцох | Үндсэн ачаалалд тооцох | Илүү оноогоор тооцох | Үндсэн ачаалалд тооцох |
| 1 | 4 | 4 | 8 | 8 | 12 | 12 |
| 2 | 8 | 6 | 16 | 12 | 24 | 18 |
| 3 | 12 | 8 | 24 | 16 | 36 | 24 |
| 4 | 16 | 10 | 32 | 20 | 48 | 30 |
| 5 | 20 | 12 | 40 | 24 | 60 | 36 |
| (Цахим сургалт 1-10) | | | | | | |
| 6 | 24 | 14 | 48 | 28 | 72 | 42 |
| 7 | 28 | 16 | 56 | 32 | 84 | 48 |
| 8 | 32 | 20 | 64 | 40 | 96 | 60 |
| (Цахим сургалт 11-20) | | | | | | |
| 9 | 36 | 24 | 72 | 48 | 108 | 72 |
| 10-14 | 40 | 28 | 80 | 56 | 120 | 84 |
| (Цахим сургалт 21-29) | | | | | | |



Магистрын цахим сургалтад хичээл заасан багшийн гүйцэтгэлийг тооцох

| Гүйцэтгэл | Оноо |
|--|--------------|
| 1. Хичээлийн хөтөлбөр, оюутны гарын авлагыг англи хэл дээр шинээр боловсруулах | 20 |
| 2. Эргэх холбоотой үнэлгээг зохион байгуулах | 30 (улиралд) |
| 3. Шинэчлэн бичүүлсэн цахим лекцийн нэг цаг тутамд | 4 |
| 4. Нэг багц цагийн хичээл шинээр бэлтгэх | 100 |
| 5. Хоёр багц цагийн хичээл шинээр бэлтгэх | 200 |

АШУУИС-ийн тэнхимийн ангилал



| Тэнхим | Бүрэлдэхүүн сургууль |
|--|---------------------------------|
| 1. Ерөнхий эрдмийн тэнхим | |
| 1. Биеийн тамирын тэнхим | Био-Анагаахын сургууль |
| 2. Гадаад хэлний тэнхим | Био-Анагаахын сургууль |
| 3. Ерөнхий эрдмийн тэнхим | Сувилахуйн сургууль |
| 2. Анагаахын суурь боловсролын тэнхим | |
| 4. Эмнэлзүйн лабораторийн тэнхим | Анагаах ухааны сургууль |
| 5. Анатомийн тэнхим | Био-Анагаахын сургууль |
| 6. Биохимийн тэнхим | Био-Анагаахын сургууль |
| 7. Анагаахын химийн тэнхим | |
| 8. Биологийн тэнхим | |
| 9. Бичил амь судлал, халдварын сэргийлэлт, хяналтын тэнхим | |
| 10. Гистологийн тэнхим | |
| 11. Дархлаа судлалын тэнхим | |
| 12. Молекул биологи, удам зүйн тэнхим | |
| 13. Физик мэдээлэл зүйн тэнхим | |
| 14. Физиологийн тэнхим | |
| 15. Харилцааны ур чадварын тэнхим | |
| 16. Эм судлалын тэнхим | |
| 17. Эмгэг судлал, шүүх эмнэлгийн тэнхим | |
| 18. Эмгэг физиологийн тэнхим | |
| 19. Орчны эрүүл мэндийн тэнхим | Нийгмийн эрүүл мэндийн сургууль |
| 20. Урьдчилан сэргийлэх анагаах ухааны тэнхим | Нийгмийн эрүүл мэндийн сургууль |
| 21. Шим тэжээл судлалын тэнхим | |
| 22. Эпидемиологи, биостатистикийн тэнхим | |
| 23. Эрүүл мэндийн бодлогын тэнхим | |
| 24. Эрүүл мэндийн нийгмийн ажил, нийгмийн ухааны тэнхим | |
| 25. Анагаахын суурь шинжлэх ухааны тэнхим | Сувилахуйн сургууль |
| 26. Бие бялдар судлалын тэнхим | |
| 27. Насанд хүрэгчдийн сувилалын тэнхим | |
| 28. Нийгмийн эрүүл мэндийн сувилалын тэнхим | |
| 29. Суурь сувилалын тэнхим | |
| 30. Эх барих, эх хүүхдийн тэнхим | |
| 31. Эм найруулагчийн тэнхим | Эм зүйн сургууль |
| 32. Эмийн технологийн тэнхим | |
| 33. Эмийн хими, ургамал судлалын тэнхим | |
| 34. Эмнэлзүйн эмзүй, менежментийн тэнхим | |
| 35. Эрүүл мэндийн судалгааны тэнхим | Эрдмийн сургууль |
| 36. Эрх зүй, боловсрол судлалын тэнхим | Эрдмийн сургууль |
| 3. Эмнэлзүйн тэнхим | |
| 37. Арьс судлалын тэнхим | Анагаах ухааны сургууль |
| 38. Бөөр судлалын тэнхим | Анагаах ухааны сургууль |
| 39. Гэмтэл согог судлалын тэнхим | |
| 40. Дотоод шүүрэл судлалын тэнхим | |
| 41. Зүрх судас судлалын тэнхим | |
| 42. Мэдрэл судлалын тэнхим | |
| 43. Мэс заслын тэнхим | |
| 44. Нүд судлалын тэнхим | |
| 45. Өрхийн анагаах ухааны тэнхим | |
| 46. Радиологийн тэнхим | |
| 47. Ревматологийн тэнхим | |

-
- 48. Сэргээн засах анагаах ухааны тэнхим
 - 49. Сэтгэцийн эрүүл мэнд судлалын тэнхим
 - 50. Уушги, харшил судлалын тэнхим
 - 51. Хавдар судлалын тэнхим
 - 52. Халдварт өвчин судлалын тэнхим
 - 53. Хоол боловсруулах эрхтэн судлалын тэнхим
 - 54. Хүүхдийн анагаахын тэнхим
 - 55. Цус судлалын тэнхим
 - 56. Чих хамар хоолой судлалын тэнхим
 - 57. Эх барих эмэгтэйчүүдийн тэнхим
 - 58. Яаралтай тусламж, мэдээгүйжүүлэг судлалын тэнхим
-

- 59. Нүүр амны гажиг заслын тэнхим
 - 60. Нүүр амны мэс заслын тэнхим
 - 61. Нүүр амны согог заслын тэнхим
 - 62. Нүүр амны технологи, эрүүл ахуйн тэнхим
 - 63. Нүүр амны эмчилгээний тэнхим
 - 64. Хүүхдийн нүүр ам судлал, урьдчилан сэргийлэлтийн тэнхим
 - 65. Шүдний тулгуур эд, сувгийн эмчилгээний тэнхим
-

- 66. Дотор өвчин судлалын тэнхим
 - 67. Зүү төөнө, заслын тэнхим
 - 68. Монгол анагаах ухаан судлалын тэнхим
 - 69. Уламжлалт эмчилгээний тэнхим
 - 70. Уламжлалт жор судлалын тэнхим
 - 71. Уламжлалт бариа заслын тэнхим
-

Нүүр ам судлалын
сургууль

Монгол анагаах ухааны
олон улсын сургууль

